

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

/2024 оны эхний хагас жилийн байдлаар/

2024.06.30

Эрдэнэт хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>							
1	3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхийг эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	3. Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ	2021 - 2024	Арилжааны банк 21900.0 Орон нутгийн төсөв 285.0 Тусгай сангийн эх үүсвэр 3200.0 Төсөл хөтөлбөр 5600.0 Нийт 30985.0	Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 50-аас доошгүй ААН-д хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын дэмжлэг үзүүлнэ	Аймгийн хэмжээнд 2021-2023 онд хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгож буй 5-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд 31 аж ахуйн нэгж, 72 иргэн хамрагдаж 18.5 тэрбум, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 6 аж ахуйн нэгжид 988.3 тэрбум, Хоршоо хөгжүүлэх сангаас нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 79 иргэн, аж ахуйн нэгж, хоршоонд нийт 1.3 сая, Япон улсын Жайка төслөөс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 4 төсөлд 3.2 тэрбум төгрөг, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Бест” хөтөлбөрөөс 37 иргэн, аж ахуйн нэгжид 1.9 тэрбум нийт 163 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 25.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 28 иргэн тэнцэж 280.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Бест” хөтөлбөрөөс 4 аж ахуйн нэгжид 40.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг, “Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих” (PROGRES) төслөөс 28 жижиг, дунд үйлдвэрлэгч, гарааны бизнес эрхлэгч нарыг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө шинэчлэн сайжруулахад нийт 250.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ-аас “Гарааны бизнес-2022” төсөл зохион байгуулж 3	90

					<p>аж ахуйн нэгжид 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт олгосон.</p> <p>2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 4 аж ахуйн нэгж 674.0 сая төгрөг, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 2 аж ахуйн нэгжид 900.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоонд 250.0 сая, “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд 11 хоршоонд 2.5 тэрбум төгрөгийн зээл олгогдож нийт 27 ажлын байр шинээр нэмэгдсэн байна.</p> <p>Аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс 4 аж ахуйн нэгж 185.0 сая төгрөгийн зээл олгосон.</p> <p>2021-2024 онд нийт 316 аж ахуйн нэгж, хоршоо, иргэнд 31.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон байна.</p>	
2	3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Олон улсын байгууллага 59.1	<p>Ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлснээр 100 орчим ажлын байр бий болсон байна. Ээрэх үйлдвэрийн хүчин чадлыг 300 тонноор нэмэгдүүлнэ.</p> <p>2021-2023 онд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд гадаадын болон дотоодын төсөл хөтөлбөрт хамруулахаар зөвлөгөө, мэдээлэл, сургалтад хамруулснаар “Энх-Ундрам үйлс” ХХК нь 50.0 сая төгрөгийн санхүүжилт авч хонь, тэмээний ноосыг анхан шатны боловсруулалтаас эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээлд нийлүүлж байна.</p> <p>“Эрдэнэт кашмер” ХХК нь технологийн шинэчлэл хийснээр жилдээ 4400 тн ноос угаах хүчин чадалтай болж өргөжсөн нь өмнө ашиглаж байсан машинаас 2.5 дахин илүү хүчин чадалтай болж, дотоодын мал аж ахуйн түүхий эдийг ашиглан гэр ахуйн хэрэглээний оёмол бүтээгдэхүүн, ноолуур болон ноосон бэлэн хувцсыг үйлдвэрлэж бүтээгдэхүүний төрлөө нэмэгдүүлсээр байна. Мөн тус компанийн сүлжмэлийн үйлдвэрт Герман улсад үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж суурилуулж хүчин чадлыг нэмэгдүүлснээр 100 гаруй ажлын байр бий болгож, сүлжмэл хувцасны үйлдвэр жилд 11000 ширхэг цамц, оёдлын үйлдвэр нь жилд 90000 ширхэг оёмол бүтээгдэхүүн, нэхмэлийн үйлдвэр нь жилд 50000 метр тэмээ, хонь, сарлагийн ноос, хөөврөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж ОХУ, Европын холбооны орнуудад экспортолж байна. “Эрдэнэт хивс” ХХК ноос ноолуурын угаах</p>	90

					<p>цехэд 2 төрлийн сэгсрэх машин суурилуулснаар хог хаягдлыг хуурайгаар нь ачиж зайлуулдаг болсноор лагийн хэмжээ буурсан</p> <p>"Мөнх баян алт" ХХК нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төсөлд хамрагдаж хонины ноосон эсгий тавчик, эсгий дотортой арьсан гутал, ажлын эсгий гутал үйлдвэрлэх чиглэлээр 9.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг авснаар 13 ажлын байр хадгалагдан, 6 ажлын байр шинээр бий болж жилд 2500–3000 хос эсгий табчик үйлдвэрлэн ОХУ руу экспортолж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд түүхий эд бэлтгэн, нийлүүлэгч 7 иргэн 925 м.кв багтаамж бүхий агуулахтайгаар тогтвортой үйл ажиллагаа явуулж, жилд 370 тн хонины ноос, 165 тн ноолуур, 310.0 мянган ширхэг арьс шир бэлтгэн анхан шатны тордолт хийн үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлж байна.</p> <p>2024 оны байдлаар ноос ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Орхон хаан сүлжмэл ХХК, Түмэн сүлжээ ХХК нь үйлдвэрийн үйл ажиллагаагаа өргөтгөн шинээр 4-5 ажлын байр нэмэгдүүлэн, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийснээр бүтээгдэхүүний загвар сайжирч, тоо хэмжээг нэмэгдүүлэн өөрийн нэрийн барааны дэлгүүртэй болсон. Мөн “Жижиг дунд үйлдвэрийн газар”-тай хамтран зохион байгуулсан “Цахим каталоги”-т орон нутгийн сүлжмэлийн салбарыг төлөөлөн бүтээгдэхүүнээ байршуулж Өвөрхангай, Дархан-Уул аймаг, нийслэлээс 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний захиалга авч хамтран ажиллаж байна.</p>		
3	3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс	5. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна.	2020 - 2024	Орон нутгийн төсөв 2800.0	18 сум	<p>Орхон аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө 2018 онд батлагдан жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн. Төлөвлөгөө 2023 онд дуусгавар болж байгаатай холбогдуулан Жаргалант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах ажлыг “Газар орчин” ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Гэрээт ажлын хүрээнд суурь судалгаа болон хээрийн судалгааны ажлууд хийгдэж, сумын төвийн суурьшлын бүсийн тэг гортиг тогтоох ажлыг Жаргалант сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар</p>	70

	нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.				сарын 18-ны өдрийн ээлжит 12 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Шинэ сэргэлтийн бодлогын эхний үе шатыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн 4.3.1-т “Хангайн бүсийн тулгуур төв, Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна” гэсэн заалтыг хэрэгжүүлэхээр ЭЗХЯ-нд “Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040” -ийн ТЭЗҮ хийлгэх хөрөнгийг шийдвэрлэлүүлэх хүсэлтийг удаа дараа хүргүүлснээр улсын төсөвт 1.3 тэрбум төгрөгийг суулгахаар шийдвэрлэгдсэний дагуу бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаварыг шинэчлэн боловсруулж Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдууд нь стандартын шаардлага хангасан төмөр зам, авто замын сүлжээнд бүрэн холбогдсон. Шинээр байгуулагдаж буй суурьшлын бүс болох 2А, 7А хорооллын дэд бүтцийг бүрэн шийдвэрлэж, авто замын сүлжээ зургийг хийлгэн жил бүр төсөвт суулган үе шаттайгаар шийдвэрлэж байна. 2022-2024 онд тус ажилд орон нутгийн төсвөөс нийт 2.8 тэрбум төгрөгийг зарцуулсан.		
4	3.7.9. Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны	8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.	2020 - 2024	Орон нутгийн төсөв 19900.0 сая төгрөг	Түрээсийн орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Иргэдэд түрээслүүлэх түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд Дэнж баг, Баян-Өндөр хотхонд 40, 2019 онд Дэнж багийн Баян-Өндөр хотхонд 5 айлын орон сууц тус тус худалдан авч 45 айлд энгийн түрээсээр ашиглуулж байна. Монгол Улсын Засгийн газрын захиалгаар Хөгжлийн банкны санхүүжилтээр Баян-Өндөр сумын Цагаанчулуут багийн нутагт баригдсан 315 айлын орон сууцны байрыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 106 дугаар тогтоолын дагуу түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэдэд олгосон. 2024 оны 5 дугаар сарын байдлаар нийт 30 иргэн орон сууцны байрны төлбөрийг бүрэн төлж өмчлөх	90

	хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.					эрхийн гэрчилгээ авч, Монгол Улсын Хөгжлийн банкинд 2747.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгээд байна. / байрны төлбөр хийсэн иргэн, төлсөн мөнгөн дүн нэмэгдээгүй юм уу. 1-р сараас хойш нэмэгдсэнгүй/ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Орон сууцны хөтөлбөр”-ийг батлуулан Баян-Өндөр сумын Уртын гол багт 260 айлын 5 блок орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Тус барилгын төсөвт өртөг нь 27.4 тэрбум төгрөг байна. Тус барилгад 2021 онд 3.0 тэрбум, 2022 онд 13.1 тэрбум, 2023 онд 3.8 тэрбум төгрөг, нийт 19.9 тэрбум төгрөгийн санхүүжилтыг олгон ажилласнаар одоогийн байдлаар тус төслийн гүйцэтгэл 73 хувьтай байна. Эхний ээлжинд ашиглалтад орсон 3 блок барилгыг хүлээн авч, иргэдийг оруулах ажлыг зохион байгуулснаар 17 иргэн түрээсээр, 139 иргэн худалдан авч нийт 156 айл тус орон сууцанд ороод байна.	
5	3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Орон нутгийн төсөв 551.9	Барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр хийх “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Дани улсын “СВЕКО Дэнмарк” ХК шалгарсан бөгөөд Монгол талын зөвлөхөөр “Мон консалт” ХХК ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Эрдэнэт хотын үерийн хамгаалалтын далан сувгийг инженерийн хийцэд оруулах ажлын зураг төслийг боловсруулан банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу тендер зарлаж, тендерийг 5 сарын 23-нд нээн үнэлгээ хийгдэж байна. Тус төслийг хэрэгжүүлэх төслийн нэгжийг байгуулж, төслийн усан хангамжийн хүрээнд цэвэр усны шугам өргөтгөх, гэр хорооллын усны хугдгуудыг төвлөрсөн системд холбох ажлын тендерийг нээж үнэлгээ хийгдсэн. Төслийн ажлын явцад газар дээр нь 6 удаагийн хамтарсан үзлэг хийсэн. Төслөөс нийт 14 сая долларын хөрөнгө оруулалт хийхээс 10.65 сая долларыг үерийн хамгаалалтын далан суваг барих ажилд, 3.35 сая долларыг хотын инженерийн шугам сүлжээ шинэчлэх ажилд зарцуулахаар төлөвлөсөн. 2020-2023 онд орон нутгийн төсвөөс нийт 511.9 сая төгрөгийг	70

						зарцуулан 3.6км урт үерийн хамгаалалтын суваг шинээр барьснаар аймгийн хэмжээнд нийт 72.8 км урт үерийн хамгаалалтын суваг бий болсны 10.2 км нь инженерийн хийцлэлтэй, 11 км нь далд, 51.6 км нь байгалийн гуу жалга болон авто замын ус зайлуулах хаялага байна.	
<b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
6	4.3.11. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлэх, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах	2. Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.	2021 - 2024	Орон нутгийн төсөв 54.2	Өмнөговийн Даланзадгад, Дорноговийн Хөвсгөл, Сүхбаатарын Онгон, Дорнодын Матад, Хэнтийн Биндэр суманд нийт 5 цогцолбор байгуулна. Хэнтийн Баянхутаг, Сүхбаатарын Түмэнцогт, Дундговийн Сайнцагаан суманд нийт 3 цогцолбор байгуулна.	Гамшигт тэсвэртэй хотууд төслийн хүрээнд аймгийн хэмжээнд суурилагдсан нийт 12 гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дуут дохионуудыг нэгдсэн удирдлагын радио системийг 2022 онд суурилуулан ашиглаж байна. Энэ нь цаг хугацаа алдалгүй гамшгийн аюулыг иргэдэд эрт зарлан мэдээлэх боломж бүрдэж байгаагаараа ач холбогдолтой төдийгүй улсын хэмжээнд радио системээр холбогдсон анхны аймаг болсон. Мөн гамшгаас хамгаалах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн тоног төхөөрөмжүүдэд хэт богино долгионы радио станцууд иридиум утас, нисдэг камер буюу дрон (MAVIC2), бүс нутгийн хэмжээнд яаралтай шуурхай цахим хурал зохион байгуулах орчин үеийн дэлгэцийн өргөтгөл зэргийг хийсэн. 2023 онд аймгийн Засаг даргын 2023 оны А/572, А/736 дугаар захирамжаар хүчтэй газар хөдлөлтөөс үүсэх чичирхийллийн хэмжээг бичигч багаж, станцыг худалдан авч суурилуулахад орон нутгийн төсвөөс 9.0 сая, уснаас эрэн хайх, аврах ажиллагааны завины мотор, ус соруулах мотопомп авахад орон нутгийн төсвөөс 45.2 сая төгрөгийг тус тус зарцуулж, Онцгой байдлын албаны бэлтгэл бэлэн байдал хүчин чадлыг нэмэгдүүллээ. 2024 оны эхний хагас жилд Orkhon.tsag-агаар.gov.mn сайтад хагас хоногийн, 1 хоногийн, 5 хоногийн урьдчилсан мэдээнүүд тус бүр-212, 7 хоногийн урьдчилсан мэдээ-26, сарын болон улирлын урьдчилсан төлөв- тус бүр 8, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээ- 10, сэрэмжлүүлэх мэдээ-25 зохиож масс мессеж	100

	орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл өндөртэй бүсүүдэд байгуулна.				үйлчилгээгээр давтагдсан тоогоор 3870 иргэнд хүргэж цаг агаарын урьдчилан сэрэмжлүүлэх системд тухай бүр байршуулж, вэб сайт, Facebook-ээр олон нийтэд мэдээлж ажиллалаа.		
7	4.6.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.	1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавина.	2020 - 2024	Орон нутгийн төсөв 6.0	Сум, дүүргийн орон нутгийн хамгаалалтын 340 төлөвлөгөөг хянаж, тодотгол хийгдэнэ.	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн дагуу аймгийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г боловсруулж Батлан хамгаалахын сайдаар, сумдын “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г жил бүр аймгийн Засаг даргаар тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021-2022 онд ковид-19 халдварт өвчний тархалттай холбогдуулан сумдын томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүнийг үүрэн телефон утсаар тодотгох ажлыг зохион байгуулсан. Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд суман, салаа, тасагт оногдуулан данслагдсан бие бүрэлдэхүүнийг жил бүрийн I улиралд багтаан зарлан мэдээлэлтийг зохион байгуулж, тодотгон албан тушаал мэргэжилд нь оногдуулан дансалсан. Тодотголоор оногдуулан данслагдсан иргэдээс шилжилт хөдөлгөөн орсон, нас барсан, нас хэтэрсэн, эрүүл мэндийн шалтгаантай иргэдийг хасаж дайчилгааны цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээс 2 хувийг нь нөхөн томилгоожуулсан. Мөн сумдын Засаг дарга, Засаг даргын	100

						Тамгын газрын дарга нарт төлөвлөгөөний хэрэгжилтэд онцгой анхаарч, төлөвлөгөөг улирал, жил бүр тодотгох, орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг орон нутгийн тогтвортой хөгжлийн түвшин, нөөцийн бүрдүүлэлт, хүч хэрэгслийн чадавх, томилгоот нэгжийн сургалт, бэлтгэлийн үр дүнг хангаж, шаардлагатай нөөцийг жил бүр үе шаттайгаар бүрдүүлж байна. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилт, тодотголыг тайлант жилүүдэд 100 хувь биелүүлсэн.	
8	2. Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог бүрдүүлэх, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана.	2020 - 2024	Орон нутгийн төсөв 88.6 /2023 онд 4.5	Орон нутгийн цэрэг, томилгоот нэгжийн 22 сургалт зохион байгуулагдана.	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний онолын сургалтыг жил бүр зохион байгуулж байна. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг цугларалт хэлбэрээр 3 удаа, хээрийн дадлага хэлбэрээр 1 удаа зохион байгуулсан. Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/110 дугаар тушаал, Батлан хамгаалах зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны А/341 дүгээр захирамжийн дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалтыг аймагт анх удаа 3 үе шаттайгаар 4 томилгоот нэгжийн сургалтыг зохион байгуулж, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн удирдлага болон бие бүрэлдэхүүн томилгоот албан тушаалын үүрэгт нь сурган дадлагажуулах, үүрэг гүйцэтгэх бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, онц болон дайны байдлын үед үүргээ алдаагүй биелүүлэх ур чадвар олгох, бататгах бүрэлдэхүүний дадлага, чадварыг дээшлүүлэхэд чиглэн ажилласан. Орон нутгийн хамгаалалтын сургалтыг тайлант жилүүдэд 100 хувь биелүүлсэн.	100	
9	3. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв	2020 - 2024	-	Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөний боловсруулалт бүрэн хийгдэнэ.	Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын стратегийн удирдамж, Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн мн/270, мн/418 тоот дайчилгааны даалгавар, Цэргийн дайчилгааны заавар, “Зэвсэгт хүчний анги, самбарыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, “Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу жил бүрийн II, IV улиралд тодотголыг	100	



		байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг шинэчилнэ.				Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудтай хийж, акт нотломжийг Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна. Дайчилгааны бэлтгэл нөөцийн I, II дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтуудыг Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудын сургалтын материаллаг баазыг түшиглэн Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалын дагуу тогтмол зохион байгуулснаар бэлтгэл нөөц 14 хувиар өссөн байна. Улсын дайчилгааны төлөвлөгөө батлагдахтай холбогдуулан аймгийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдон ажиллаж байна.	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
10	5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	2020 - 2024	Улсын төсөв 2200.0 Орон нутгийн төсөв 600.0	Улаанбаатар хот болон төв суурин газрын 2000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна.	2019-2021 онд БОАЖЯ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран 249 өрхийн нүхэн жорлонг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар сольж бохирдуулагч эх үүсвэрийн тоог бууруулсан. 2020-2023 онд нийт 1218ш эко ариун цэврийн байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулснаар аймгийн хэмжээнд нийт 1718 эко ариун цэврийн байгууламжтай болоод байна. БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын отоглох цэгүүдэд аялагч, түр амрагч нарт зориулсан MNS5924:2015 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, хогийн цэг байгуулж, тухайн орон нутгийн хөрс, гүний усны бохирдол, хог хаягдлыг бууруулж, аялагч, амрагчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор улсын хэмжээнд 6 байршилд нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг Дархан нэгдэл ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд аялал жуулчлалын түр буудаллах цэг болох Эрдэнэт хаалга орчмын нийтийн ариун цэврийн байгууламжид зориулсан гүний худаг шинээр гаргах байршлыг мэргэжлийн байгууллагатай хамтран тодорхойлж, нарны гэрлээр цэнэглэгддэг шон, ангилдаг хогийн сав бүхий 3.5x7м урттай эко ариун цэврийн байгууламжийг улсын	90

						<p>төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн ашиглалтад орууллаа.</p> <p>2024 онд “Гэр хорооллын иргэдийн ус хангамжийн эх үүсвэрийг хөрсний бохирдлоос хамгаалж, эрүүл ахуйн бүсэд ойр байрлалтай 20 өрхийн нүхэн жорлонг өөрчлөх /Дэнж багт/” зорилгоор зураг төсвийг шинэчлэн боловсруулж худалдан авах ажиллагааг зарласан ч амжилтгүй болсон тул дахин зарлаад байна.</p> <p>Баян-Өндөр сумын ЗДТГ, БОАЖГ хамтран өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж /эко-00/ барьсан иргэдэд урамшуулал олгох журмыг Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, тус ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгууллаа.</p>	
11	5.1.8. Уул уурхайн ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2020 - 2024	Орон нутгийн төсөв 53.0	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	<p>Аймгийн хэмжээнд нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттай хийснээр 2020-2023 онд нийт 14.9 га талбайг нөхөн сэргээгээд байна.</p> <p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын 2020-2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусгуулан батлагдсаны дагуу Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ил уурхайн 3 дугаар овоолго дээр 3.9 га-д, Очир төв ХХК-ийн Тасгийн овооны карьерт 1га-д тус бүр техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлж ажилласан. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ил уурхайн 8 дугаар овоолгоны хойд тал 2 га-д биологийн нөхөн сэргээлт, Дэлт хошуу ХХК-ийн Дэлт толгойн карьерт 1 га-д техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэхээр 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулан БОАЖЯамаар батлуулаад байна. Улсын хэмжээнд эвдэрч эзэнгүй орхигдсон 8000 га талбайгаас Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 2021-2024 онд 2000 га-д техникийн нөхөн сэргээлт хийхээс 2024 оны 06 дугаар сарын байдлаар 1300 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж, 700 га-д нөхөн сэргээлт хийх худалдан авах ажиллагаа</p>	90

						зарласан боловч гомдол гарч эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт буюу Чингэлийн гол хөндлөн намагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй Отгонтэнгэр-Оргил ХХК-нд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.	
12	5.1.11. "Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	2. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.	2020 - 2024	Орон нутгийн төсөв 154.6	Хөв цөөрмийг 3-аас доошгүй газарт шинээр байгуулах, 120-аас доошгүй булаг шандны эхийг хашиж хамгаалсан байна.	Дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах Баянцагаан, Далиу, Долоонбулаг, Хөөвөр, Хүрэнбулаг зэрэг 5 булгийн эх ундаргыг бүрэн хашиж, сэргээн засварлах ажлыг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулан ажиллаж байна. Бүрэнбүстийн овооны хөв цөөрмийн ажлыг 2023 онд иж бүрэн дуусгахаар орон нутгийн төсвөөс 284.0 сая төгрөгийг батлуулж, тендер сонгон шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулснаар Ээлт-Өлгий ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулж эхний 110.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажил эхлээд байна. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд газар дээр нь хүрэлцэн ирж, холбогдох төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцож, хамтран ажилласнаар хөв цөөрмийн хамгаалалтын хашааны зардалд 60.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн 740м урт хамгаалалтын хашааг бариулж ашиглалтад авлаа. Даваат баг Уртбулагийн эх ундаргыг хамгаалж, мод тарьж ургуулах ажилд орон нутгийн төсвөөс 35.0 сая төгрөгийг зарцуулан булгийн эхийг хамгаалж, 220 метр төмөр хамгаалалтын хашаа барьж, голдирол дагуу улиас, бургас зэрэг 30 ширхэг мод тарилаа. 2024 онд Жаргалант сумын нутаг дэвсгэрт байрлалтай 10 булаг шандын эх, голын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Баян-Өндөр суманд шинээр 1 булаг тохижуулах, 2 булаг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. Мөн Эрдмин ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хүрэнбулгийн рашааны хамгаалалтын хашаа болон гаднах тохижилтын ажлыг иж	100

						бүрэн сэргээн засварлах, мэдээллийн самбар шинэчлэх ажлыг гүйцэтгэлээ. 2020-2024 онд аймгийн хэмжээнд нийт 19 булаг шандыг хамгаалалтад аваад байна.	
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
13	6.2.5. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.	1. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.	2021 - 2024		Хэрэгжилтийг хангана.	2020 онд татварын хуулийн шинэчлэлээр татварын бодлогоор бизнес эрхлэгчдийг дэмжих заалтууд батлагдсаныг хэрэгжүүлэн ажиллаж ирлээ. 2021 оны 07-р сард “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай” хуульд өөрчлөлт орж татварын хувь хэмжээг 0.6-2.0 хувь байхаар тогтоосон. Аймаг орон нутгаас "Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаагаас бусад уул уурхайн салбарын олборлолт, баяжуулалтын үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн бүх үл хөдлөх эд хөрөнгийн жилийн албан татварын хэмжээг 2.0 хувиар, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын цахилгаан, дулаан түгээх болон дамжуулах, шатахуун түгээх, банкны үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн бүх үл хөдлөх эд хөрөнгийн жилийн албан татварын хувь хэмжээг 1.0 хувиар, бусад салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үл хөдлөх эд хөрөнгийн жилийн албан татварын хувь хэмжээг 0.6 хувиар тогтоож бизнес эрхлэгчдийг дэмжин ажилласан. 2022 оноос мөрдөгдөж буй Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг орон нутагт төвлөрүүлэхээр хуульчилсны дагуу Орхон аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/101 тоот захирамжаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй салбар аж ахуйн нэгжүүдийн пос машины тохиргоог өөрчилж шинэчлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнгээр 2022 онд орон нутгийн төсөвт 94.1 тэрбум, 2023 онд орон нутгийн төсөвт 126.1 тэрбум, 2024 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 46.1 тэрбум төгрөгийн хуваарилалт хийлгэн ажилласан. 2023 онд 15 салбар, 2024 онд 2 салбар шинээр бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж эхэлснээр одоогийн байдлаар банк санхүү	100

					<p>аудитын 22, даатгалын 9, мэдээлэл харилцаа холбооны 10, худалдааны 22, шатахуун түгээх 12, үйлдвэрлэлийн чиглэлээр 6, үйлчилгээний чиглэлээр 9, эм эмнэлгийн хэрэгслийн худалдаа 6, үнэт цаас арилжааны 1, хоол үйлдвэрлэлийн 2, барилгын чиглэлээр 1, барьцаалдан зээлдүүлэх үйлчилгээний 1, боловсролын 1, газар тариалан 1, бусад чиглэлээр 17, нийт 120 салбар тогтмол үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан 2024 оноос мөрдөж эхлэх орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг Орхон аймгийн төвийн сумын хилийн цэсийн дотор 50 хувиар, аймаг, сумын хилийн цэсийн дотор баригдсан нийтийн зориулалттай орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг 90 хувиар, гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тухайн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 90 хувиар, гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлогод ноогдох татварыг тус тус хөнгөлөх тухай заалтуудын талаарх мэдээллийг байгууллагын вэб хуудас, <a href="https://www.youtube.com/@user-mw1iv4sq6q/videos">https://www.youtube.com/@user-mw1iv4sq6q/videos</a> цахим хаягт 6 удаа байршуулж, нийтэд мэдээлж сурталчиллаа.</p>		
14	6.2.8. Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын	1. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг	2020 - 2024	Орон нутгийн төсөв 7879.4 Улсын төсөв 20637.0	Гэр хорооллын 3500 өрх инженерийн сүлжээнд холбогдсон байна.	2021 оноос аймгийн хэмжээнд Бидний гудамж бидний гэр”, “Хашаандаа хаус” хөтөлбөрийг хэрэгжүүлж гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажилд орон нутгийн төсвөөс нийт нийт 2.9 тэрбум төгрөг зарцуулсан байна. Уг ажлын хүрээнд гэр хорооллын 7 багт нийт 8847 м урт дулаан, хэрэглээний халуун ус, цэвэр усны салбар шугамыг барьж бетон сувагт хийж, 3916м урт бохирын шугам, 99 бохирын худаг хийгдэж нийт 1245 айл өрх инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдсэнээс 253 айл өрх холбогдоод байна.	90

	чанарыг дээшлүүлнэ.	бүрт гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцлийг сайжруулна.			<p>Мөн инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэхээр улсын төсвийн нийт 19.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Гэр хорооллын Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн Ус дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх шугам сүлжээний угсралтын ажлыг 2022 оноос эхлүүлснээр одоогийн байдлаар 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч ус дулаан хуваарилах төвийн дотор тоног төхөөрөмжийг угсарч дуусган, заслын болон гадна шугам угсралтын ажил 75%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</li> <li>Улсын төсвийн 1.37 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Их залуу багт төв дулаан, цэвэр усны шугам шинээр тавих, ус дулаан дамжуулах төвийн барилга барих 1.7 км 3 хос гадна инженерийн шугам сүлжээ угсралтын ажлыг 2022 оноос эхлүүлснээр ажил бүрэн дуусч улсын комисс ажиллалаа.</li> <li>Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хотын нийтийн орон сууцнууд болон аж ахуйн нэгж, байгууллагыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барих ажилд одоогийн байдлаар 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдон ажил 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</li> </ul> <p>Ариутгах татуургын 3-р коллекторын төв шугамын ажлыг 2022 оноос эхлүүлснээр Ф200-Ф600мм-ийн гол шугам 3.6км, салбар шугам 2.55км, 1500мм-ийн 73ш худаг шугамын угсралт, дулаалга, нягтруулалт зэрэг ажлууд хийгдэж тус ажил 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>Одоогийн байдлаар “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-ийн өмчлөлд буй гэр хорооллын инженерийн шугам сүлжээнээс нийт 321 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад дулаан эрчим хүч, ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл олгосон байна.</p>	
15	6.2.10. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын	1. Аймаг, сумын төвүүдийн хог	2021 - 2024	Орон нутгийн төсөв 4108.0	<p>“Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” төслийг хэрэгжүүлэх гэрээг байгуулж, Бүгд Найрамдах Польш</p>	90

	асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.				улсын Засгийн газар, Монгол улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэхээр Польш улсын ППЭйч Мелиорекс ХХК шалгарч, түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын гэрээг Орхон аймагтай 2019 онд байгуулсан. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох хог хаягдлыг татан зайлуулах 12 ширхэг машин механизмыг бүрэн хүлээн авч Хот тохижуулах газар хүлээлгэн өгсөн. Төслийн хүрээнд баригдах хог ангилан ялгах үйлдвэрийн барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Төслийн хүрээнд баригдах хог ангилан ялгах үйлдвэрийн барилгын ажил төслийн гүйцэтгэгч, Орхон аймагтай байгуулсан ажлын гэрээний хугацаа дууссантай холбоотойгоор гэрээний хугацааг сунгах талаар 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр хийгдэж гэрээ 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хүртэл сунгагдсан. 2023 онд орон нутгийн төсвийн нийт 2.65 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хот тохижуулах газрын парк шинэчлэлтийг хийсэн. Үүнд: Хог хаягдал ачиж тээвэрлэх 20 ширхэг хөдөлгөөнт чингэлэг худалдан авсан. Мөн машин механизм, хөдөлгөөнт чингэлэг нийлүүлэх гүйцэтгэгчээр шалгарсан Хьюндай ХХК 45 ширхэг хөдөлгөөнт чингэлэг, хог хаягдлын ачиж тээвэрлэх 7 ширхэг автомашиныг нийлүүлж парк шинэчлэлт хийгдлээ. Парк шинэчлэлтийг хийснээр Хот тохижуулах газарт 49 машин механизм, 110 хөдөлгөөнт чингэлэгтэй болж, гэр хорооллын хог ачилтыг жилд 10-11 удаагийн хог татан авах нөхцөл бүрдүүлсэн нь өмнөх жилүүдээс хог татан авалтыг 3-4 удаагийн давтамжаар нэмэгдүүлээд байна.	
16	6.2.12. Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч,	1. Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж,	2021 - 2024	Орон нутгийн төсөв 28060.0	Албаны орон сууцаар хангагдсан байна.	Төрийн албан хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд: Эрүүл мэнд болон боловсролын салбар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, аймаг, сумын ЗДТГ, ХХҮХ зэрэг байгууллагуудын нийт 54 албан хаагч төрийн албан хаагчдын түрээсийн орон сууцанд амьдарч байна.	90

	<p>төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.</p>	<p>амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.</p>				<p>2021 онд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажилчдад зориулагдан барьсан “Уурхайчин-1”, “Уурхайчин-2” хороололд 3, Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан орон сууцжуулах хөтөлбөрт 7, нийт 17 алба хаагч хамрагдаж ипотекийн зээл авч орсон байна. Орон нутгаас газрын асуудлыг шийдвэрлүүлж үндэсний аюулгүй байдлын тусгайлсан чиг үүрэг бүхий албан байгууллагын 5 алба хаагчид хашаа байшин барьж өгөхөд орон нутгийн төсвөөс 57.5 сая төгрөгийг зарцуулан дэмжлэг үзүүлсэн.</p> <p>2022 онд Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцанд БОЭТ-ийн 40 ажилтан хөнгөлөлттэй үнээр буюу м/кв нь 1.350.000 төгрөг байхаар гэрээ байгуулсан ба барилгын гүйцэтгэл 20%-тай явагдаж байна. Мөн Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс 30 ажилтанд орон сууц худалдан авахад зориулан урьдчилгаа төлбөр тус бүр 20.0 сая төгрөг, Эрдэнэт сувилал орон сууц худалдан авсан нийт 6 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг, Эрдэнэт медиал эмнэлэг нь 3 албан хаагчид орон сууцны урьдчилгааг олгох эрхийн бичиг олгосон.</p> <p>2023 онд аймгийн хэмжээнд Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн сууц худалдан авах болон орон сууцны нөхцөлөө сайжруулахад 14 албан хаагчид нийт 100.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн ШШГГ-аас гэр хороололд амьдарч буй 2 алба хаагчдаа орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь тус бүр 10.0 сая төгрөг, Жаргалант сумын ЗДТГ-аас орон сууц худалдан авах 1 албан хаагчид 4.0 сая төгрөгийн ддэмжлэгийг тус тус олгосноор 2023 онд 17 төрийн албан хаагчид орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь нийт 124.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна.</p> <p>2021-2023 онд нийт 75 төрийн албан хаагчид орон сууц худалдан авах болон орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь нийт 859.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна.</p> <p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Орон сууцны хөтөлбөр”-ийг батлуулан Баян-Өндөр сумын Уртын гол багт 260 айлын 5 блок орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Тус барилгын төсөвт өртөг нь 27.4 тэрбум төгрөг</p>
--	---	---	--	--	--	---



						байна. Тус барилгад 2021 онд 3.0 тэрбум, 2022 онд 13.1 тэрбум, 2023 онд 3.8 тэрбум төгрөг, нийт 19.9 тэрбум төгрөгийн санхүүжилтыг олгон ажилласнаар одоогийн байдлаар тус төслийн гүйцэтгэл 73 хувьтай байна. Эхний ээлжинд ашиглалтад орсон 3 блок барилгыг хүлээн авч, иргэдийг оруулах ажлыг зохион байгуулснаар 17 иргэн түрээсээр, 139 иргэн худалдан авч нийт 156 айл тус орон сууцанд ороод байна. Үүнээс эрүүл мэндийн байгууллагын 2, боловсролын байгууллагын 8, төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлэх байгууллагын 7 албан хаагч тус тус хамрагдсан.	
17	6.2.13. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлог тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлог тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2021 - 2024	Улсын төсөв 4846.0 Орон нутгийн төсөв 250.0 Арилжааны банк 96632.0 Төсөл хөтөлбөр 2252.0 Нийт: 103980.0	Ажлын байр нэмэгдсэн байна.	2021-2023 онд жижиг, дунд үйлдвэрийн салбарын бүртгэл статистикийн мэдээллийг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, мэдээллийн тогтолцоог бий болгох, олон улсын жишигт нийцүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх мэдээллийн сан бий болгохоор 65 үзүүлэлтээр 1600-аад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулсан судалгаа гаргаж бүртгэлжүүлсэн. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Progress" төсөлтэй хамтран "Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих" төслийн судалгаа хийсэн. Засгийн газраас хэрэгжүүлсэн "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд 2 аж ахуйн нэгж, 208 иргэнд 2.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Мөн "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө"-нд тусгагдсан хөнгөлөлттэй зээлд аймгийн хэмжээнд 1250 төсөлд 91.1 тэрбум төгрөг, төрийн байгууллагаас олгогддог бусад хөнгөлөлттэй зээлд 84 бизнес эрхлэгч хамрагдаж 932.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон. "Эрдэнэт ШУТП" ОНӨҮГ-аас "Гарааны бизнес-2022" төсөл зохион байгуулж 3 аж ахуйн нэгж, 33 иргэнд 270.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр 12 ажлын байр шинээр нэмэгдсэн. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан Ган-Адъяа ХХК нь орон нутагт чацарганы жүүс, ундааны үйлдвэр шинээр байгуулан 4 хүнийг	90

					<p>ажлын байраар ханган ажиллаж байна. “Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих” (PROGRES) төсөл нь 28 жижиг, дунд үйлдвэрлэгч, гарааны бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг сайжруулахад 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр 9 ажлын байр нэмэгдсэн.</p> <p>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” ҮТП байгуулах төслийг хэрэгжүүлэх үйлдвэр техниологийн паркийн төслийн нэгжийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн Ерөнхий захирлын 2022 оны А/354 дугаар тушаалаар 20 инженер, техникийн ажилтнаар батлан ажлын байрын нэмэгдүүлсэн. “Эрдмин” ХХК нь олон үйлдэлт уртасгагч залгуурыг шинэчлэн олон улсын стандартад нийцсэн, орчин үеийн эрэлт хэрэгцээг хангасан QC3.0/18W, PD3.0/20W нэмэлт ухаалаг утас болон таблет, зөөврийн компьютерыг хурдан цэнэглэх боломжтой ERD-2301 загварын уртасгагч залгуурыг 1.5 метрээс 5.0 метрийн сонголттойгоор үйлдвэрлэж байна. Мөн аж ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалт бүхий ERD-2302, ERD-2303 загварын 40-50 метрийн урт утастай, дамартай уртасгагч залгуурыг шинээр үйлдвэрлэн холбогдох мэргэжлийн байгууллагаас гэрчилгээ авсан. Төгөл групп хямд, чанартай амины орон сууц барих төслийг Орхон аймагт хэрэгжүүлж эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих барилгын материалын 60 хувийг бүрдүүлэхээр дөрвөн үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Төгөл группийн леги блокийн үйлдвэр нь 2000 ширхэг блокийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 129 иргэн, аж ахуй эрхлэгчид нийт 1.1 тэрбум төгрөгийн зээлийг олгон 129 ажлын байр хадгалагдаж, 149 ажлын байр шинээр бий болсон.</p> <p>2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 4 аж ахуйн нэгж 674.0 сая төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлээд байна.</p> <p>УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй</p>
--	--	--	--	--	---

						<p>зээлээс 2 аж ахуйн нэгжид 900.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоонд 250.0 сая, аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих сангаас 4 аж ахуйн нэгжид 185.0 сая төгрөгийн зээл олгосноор 6 ажлын байр нэмэгдсэн. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 11 хоршоонд 2.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 27 ажлын байр шинээр нэмэгдсэн.</p> <p>“Шинэ хөдөө” төслийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжин тоног төхөөрөмж нийлүүлэхээр Жаргалант суманд 1.5 тэрбум, Баян-Өндөр суманд 2.2 тэрбум төгрөг батлагдан худалдан авах ажиллагаа зарлагдсанаар 8 төрлийн тоног төхөөрөмжийг төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр арьс шир, эсгий, мод модон эдлэл, малын тэжээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа 24 иргэнд 210.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй санхүүгийн дэмжлэгийг олгосноор 24 ажлын байр хадгалагдаж 30 шинэ ажлын байр бий болсон байна.</p>		
18	6.2.14.. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	2. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	2021 - 2024	Орон нутгийн төсөв 18911.9	Бизнес таатай бүрдүүлнэ.	эрхлэх орчныг	<p>2021 онд “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл 2021” цахим үзэсгэлэнд орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах ажлыг зохион байгуулж “Анд-Энерги” ХХК 45 нэр төрлийн бүтээгдэхүүнээр, “Бэкко” ХХК хамгаалалтын хувцсаар, “Эрдэнэт ШУТП” 5 төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ бүтээгдэхүүний танилцуулга болон худалдан авалтын мэдээллээр, “Уран шаглаа” ХХК, “Хамтдаа урлая” гар урлалын цех нэрийн бүтээгдэхүүнээр тус тус оролцсон. Мөн орон нутгийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах уриалга гаргаснаар 2021-2022 онд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 2097 иргэн, аж ахуйн нэгж 232.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан жижиг, дунд үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжин ажилласан. 2023 онд “Хөгжлийн шийдэл” ТББ-ын “BEST” хөтөлбөртэй хамтран орон нутагт үйл</p>	90

					<p>ажиллагаа явуулж буй ТӨҮГ, томоохон аж ахуйн нэгжүүдийн дунд орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүний үр дүнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 2020-2022 онд 1235 худалдан авалтын ажиллагаа зарлагдсанаас 81.1 хувь нь орон нутгийн аж ахуйн нэгж бараа, ажил үйлчилгээ нийлүүлсэн байна. Мөн орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 38 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээс 21 төрлийн бараа бүтээгдэхүүнийг нийт 12.6 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна. Ачит-Ихт ХХК нь 105 иргэн, аж ахуйн нэгжээс 1.3 тэрбум төгрөгийн худалдан авалт, 92 аж ахуйн нэгж, иргэнээс 12.9 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ, Эрдмин ХХК нь 173 иргэн, аж ахуйн нэгжээс 1.2 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. “Гал сэнтий” ХХК нь орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдээс ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, хоол үйлдвэрлэл, таримал мод, хэвлэлийн үйлчилгээ, бетон зуурмаг зэрэг чиглэлээр 95.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авч үйл ажиллагааг дэмжин ажилласан.</p> <p>2024 онд “Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж орон нутгийн 70 гаруй бизнес эрхлэгчид, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан 3 үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 5 аж ахуйн нэгжийг зохион байгуулалтаар оролцуулсан.</p> <p>Хөгжлийн шийдэл ТББ-ын “BEST” хөтөлбөртэй хамтран хүнсний үйлдвэрлэл, оёдлын үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, хоршооны салбарыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан салбар тус бүрт 11-18 удаагийн багц сургалт зохион байгуулан амжилттай оролцсон аж ахуйн төлөөлөлд “СЕРТИФИКАТ” гардуулан ажилласан.</p> <p>“Цах маркет” худалдааны төвд “Эрдэнэтэд үйлдвэрлэв”, Их залуу багт байрлах “Билэг” худалдааны төвд бичил үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулахаар борлуулалтын цэгүүдийг нээн ажиллуулж, түрээсийн төлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 11.8 сая төгрөгийг зарцуулсан. Тус борлуулалтын цэгүүдээр 44 иргэний 18 нэр төрлийн бүтээгдэхүүн тавигдаж 26.8 сая</p>
--	--	--	--	--	--

					<p>төгрөгийн борлуулалт хийгдэж байнгын 2 ажлын байр бий болсон.</p> <p>Орхон хаан сүлжмэл ХХК, Түмэн сүлжээ ХХК нь тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж үйлдвэрийн үйл ажиллагаагаа өргөтгөн шинээр 4-5 ажлын байр нэмэгдүүлэн ажиллаж байна.</p> <p>Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд бизнес хийх таатай орчин бүрдүүлэх зорилгоор орон нутгаас зохион байгуулсан 3 удаагийн үзэсгэлэн худалдаанд талбайн түрээсийн хөнгөлөлт үзүүлэн 120 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин оролцуулсан. "Дэлхийн жижиг, дунд үйлдвэрийн өдөр"-ийг тохиолдуулан 6-р сард Улаанбаатар хотод болох үзэсгэлэн, арга хэмжээнд орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийг оролцуулахаар зар мэдээлэл хүргэж байна.</p>	
	<b>Хэрэгжилтийн дундаж хувь</b>				91.1	